СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/206-НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn<br>Сүхбаатар сум<br>2022 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn<br>“ЦЭСБ АУДИТ” ХХК-ийн<br>аудитор: Ч.Цэрэннадмид<br>Утас: 9511 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.Төрийн аудитын санал, дүгнэлт…..................................................................3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..................................................................5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .........................................................6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.............................................................8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..................................9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... **Error! Bookmark not defined.**
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ **Error! Bookmark not defined.**
3.Аудитын тайлан ...........................................................................................9
3.1. Ерөнхий зүйл ............................................................................................16
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ................................................16
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал .........................................................14
3.4. Материаллаг байдал.....................................................................................14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ...................................................................18
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .......................................19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................20
3.8 Аудитын гол асуудал...................................................................................207
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...... 20
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ......................................................20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт......................................................................21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .........................................................21
4.1 Залруулсан алдаа ..........................................................................................21
4.2 Албан шаардлага, Зөвлөмж...........................................................................18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл......................................................20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БНХАУ | Бүгд найрамдах хятад ард улс |
| НА | Нотлох ажил |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СЭА | Сэлэнгэ аймаг |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| БСУГ | Боловсрол, соёл, урлагийн газар |

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/206-НА-СТА-ТШ3

танай ______________-ны № ______________-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Г.СУГАР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

СЭА-2022/206-НА-СТА-ТШ3 3

018020185

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **75,461,391.84** | **88,806,046.84** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **33** | **АВЛАГА** | **6,308,482.00** | **6,308,482.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,461,332.00 | 3,461,332.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 2,847,150.00 | 2,847,150.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **69,152,909.84** | **82,497,564.84** |
| **354** | **Хангамжийн материал** | 69,152,909.84 | 82,497,564.84 |
| 35420 | Аж ахуйн материал | 69,152,909.84 | 82,497,564.84 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,809,110,142.92** | **1,802,048,942.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,809,110,142.92** | **1,802,048,942.05** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,735,780,559.37** | **1,728,719,358.50** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,561,613,378.53 | 1,566,135,878.53 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (82,345,469.82) | (125,524,600.02) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,562,500.00 | 14,562,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (4,722,788.64) | (6,803,145.84) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 291,483,325.28 | 245,430,173.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (190,043,042.89) | (120,756,502.98) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 198,165,874.30 | 211,870,546.88 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (94,707,960.72) | (103,435,728.86) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,499,760.00 | 2,499,760.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (543,552.00) | (743,328.00) |
| 39217 | Ном | 39,818,535.33 | 45,483,805.59 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **73,329,583.55** | **73,329,583.55** |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (310,416.45) | (310,416.45) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 73,090,000.00 | 73,090,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,884,571,534.76** | **1,890,854,988.89** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,884,571,534.76** | **1,890,854,988.89** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,884,571,534.76 | 1,890,854,988.89 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,035,463,087.36 | 1,035,463,087.36 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,035,463,087.36 | 1,035,463,087.36 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(325,618,897.29)** | **(319,335,443.16)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (325,618,897.29) | (321,096,397.29) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,760,954.13 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,174,727,344.69 | 1,174,727,344.69 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,884,571,534.76** | **1,890,854,988.89** |

## 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,382,305,920.24** | **1,371,443,726.11** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,537,772.24** | **78,418,489.14** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **27,537,772.24** | **78,418,489.14** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 23,804,410.40 | 64,741,243.14 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 3,733,361.84 | 13,677,246.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,354,768,148.00** | **1,293,025,236.97** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,354,768,148.00** | **1,276,596,236.97** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 86,897,548.00 | 88,507,436.97 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,267,870,600.00 | 1,188,088,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **16,429,000.00** |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | - | 10,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 934,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 4,895,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,450,056,587.29** | **1,369,682,771.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,450,056,587.29** | **1,369,682,771.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,291,555,472.43** | **1,319,159,854.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **932,713,614.00** | **930,948,855.95** |
| 210101 | Үндсэн цалин | 578,167,740.00 | 649,404,191.98 |
| 210102 | Нэмэгдэл | 281,724,109.00 | 229,498,229.73 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 72,821,765.00 | 52,046,434.24 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **117,682,207.14** | **121,397,332.24** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,497,615.56 | 84,697,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,511,383.56 | 9,240,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,479,320.03 | 7,392,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,854,133.47 | 1,804,814.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,339,754.52 | 18,262,518.11 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **86,897,548.00** | **86,061,836.97** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,763,608.00 | 11,024,412.73 |
| 210302 | Түлш, халаалт | 67,363,940.00 | 63,313,424.24 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,770,000.00 | 11,724,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **12,762,029.00** | **18,836,391.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,118,040.00 | 1,199,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,161,260.00 | 1,175,990.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,769,200.00 | 3,014,960.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 4,895,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,005,079.00 | 2,270,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,708,450.00 | 6,280,641.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **6,769,120.00** | **41,944,164.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 620,200.00 | 312,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,548,920.00 | 41,631,764.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,273,120.00** | **5,215,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 8,273,120.00 | 5,215,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **644,000.00** | **506,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 644,000.00 | 506,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **7,080,300.00** | **10,100,230.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,274,500.00 | 8,948,230.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 555,800.00 | 1,152,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,250,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **118,733,534.29** | **104,149,444.01** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 893,900.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,777,600.00 | 5,698,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 108,062,034.29 | 98,450,844.01 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **158,501,114.86** | **50,522,917.81** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,402,450.00** | **44,886,700.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,319,450.00 | 44,186,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,083,000.00 | 700,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **128,098,664.86** | **5,636,217.81** |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 128,098,664.86 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,636,217.81 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(67,750,667.05)** | **1,760,954.13** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(67,750,667.05)** | **1,760,954.13** |
| | | | |

## 3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,366,631,588.00** | **1,293,025,236.97** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,366,631,588.00** | **1,293,025,236.97** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,354,768,148.00** | **1,276,596,236.97** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 86,897,548.00 | 88,507,436.97 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,267,870,600.00 | 1,188,088,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **11,863,440.00** | **16,429,000.00** |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | - | 10,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 934,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,863,440.00 | 4,895,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,341,638,888.00** | **1,270,899,336.97** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,341,638,888.00** | **1,270,899,336.97** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,184,082,773.14** | **1,220,623,919.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 932,790,946.00 | 930,948,855.95 |
| 210101 | Үндсэн цалин | 578,245,072.00 | 649,404,211.68 |
| 210102 | Нэмэгдэл | 281,724,109.00 | 229,498,210.03 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 72,821,765.00 | 52,046,434.24 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **117,722,730.14** | **121,397,332.24** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,538,138.56 | 84,697,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,511,383.56 | 9,240,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,479,320.03 | 7,392,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,854,133.47 | 1,804,814.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,339,754.52 | 18,262,518.11 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **86,897,548.00** | **86,061,836.97** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,763,608.00 | 11,024,412.73 |
| 210302 | Түлш, халаалт | 67,363,940.00 | 63,313,424.24 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,770,000.00 | 11,724,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **12,124,029.00** | **10,033,700.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 2,118,940.00 | 1,275,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,166,620.00 | 998,890.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,768,650.00 | 2,214,960.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,572,519.00 | 2,257,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,497,300.00 | 3,287,050.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **7,722,600.00** | **44,960,664.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 495,200.00 | 436,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,067,400.00 | 41,879,264.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,160,000.00 | 2,645,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,618,120.00** | **5,624,600.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 564,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,618,120.00 | 5,060,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **746,000.00** | **506,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 746,000.00 | 506,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,080,300.00 | 16,263,930.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,274,500.00 | 15,111,930.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 555,800.00 | 1,152,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,250,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,380,500.00** | **4,827,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 893,900.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,486,600.00 | 4,827,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **157,556,114.86** | **50,275,417.81** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **29,457,450.00** | **44,639,200.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,374,450.00 | 43,939,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,083,000.00 | 700,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 128,098,664.86 | 5,636,217.81 |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 128,098,664.86 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,636,217.81 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **24,992,700.00** | **22,125,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **24,992,700.00** | **22,125,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **24,992,700.00** | **22,125,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **24,992,700.00** | **22,125,900.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 14,699,100.00 | 20,190,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 10,293,600.00 | 1,935,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -24,992,700.00 | -22,125,900.00 |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | 0.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,035,463,087.36 | 1,174,727,344.69 | (325,618,897.29) | | 1,884,571,534.76 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 4,522,500.00 | | 4,522,500.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,035,463,087.36** | **1,174,727,344.69** | **(321,096,397.29)** | **-** | **1,889,094,034.76** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | | | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,035,463,087.36** | **1,174,727,344.69** | **(321,096,397.29)** | **-** | **1,889,094,034.76** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,035,463,087.36** | **1,174,727,344.69** | **(321,096,397.29)** | **-** | **1,889,094,034.76** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,035,463,087.36** | **1,174,727,344.69** | **(321,096,397.29)** | **-** | **1,889,094,034.76** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,760,954.13 | | 1,760,954.13 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,035,463,087.36** | **1,174,727,344.69** | **(319,335,443.16)** | **-** | **1,890,854,988.89** |

## 5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,293,366,800.00** | **1,270,970,289.16** | **22,396,510.84** | **98.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,293,366,800.00** | **1,252,410,889.16** | **40,955,910.84** | **96.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,248,361,800.00** | **1,207,771,689.16** | **40,590,110.84** | **96.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **935,052,100.00** | **930,948,855.95** | **4,103,244.05** | **99.56** |
| 210101 | Үндсэн цалин | 640,444,500.00 | 649,404,211.68 | - 8,959,711.68 | 101.40 |
| 210102 | Нэмэгдэл | 241,512,700.00 | 229,498,210.03 | 12,014,489.97 | 95.03 |
| 210104 | Урамшуулал | 53,094,900.00 | 52,046,434.24 | 1,048,465.76 | 98.03 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **121,659,200.00** | **121,397,332.24** | **261,867.76** | **99.78** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,697,000.00 | 84,697,000.00 | - | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,240,500.00 | 9,240,500.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,392,500.00 | 7,392,500.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,848,100.00 | 1,804,814.13 | 43,285.87 | 97.66 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,481,100.00 | 18,262,518.11 | 218,581.89 | 98.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **102,832,400.00** | **86,061,836.97** | **16,770,563.03** | **83.69** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,700,000.00 | 11,024,412.73 | 3,675,587.27 | 75.00 |
| 210302 | Түлш, халаалт | 76,408,400.00 | 63,313,424.24 | 13,094,975.76 | 82.86 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,724,000.00 | 11,724,000.00 | - | 100.00 |
| 210304 | Байрны түрээс | | | - | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,025,400.00** | **9,099,700.00** | **925,700.00** | **90.77** |
| 210401 | Бичиг хэрэг | 761,800.00 | 761,800.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 998,890.00 | 1,110.00 | 99.89 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,215,300.00 | 2,214,960.00 | 340.00 | 99.98 |
| 210404 | Ном, хэвлэл | 889,800.00 | - | 889,800.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,843,300.00 | 1,837,000.00 | 6,300.00 | 99.66 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,315,200.00 | 3,287,050.00 | 28,150.00 | 99.15 |
| **2105** | **Нормативт зардал** | **45,744,400.00** | **44,960,664.00** | **783,736.00** | **98.29** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 452,800.00 | 436,400.00 | 16,400.00 | 96.38 |
| 210502 | Хоол, хүнс | 42,645,900.00 | 41,879,264.00 | 766,636.00 | 98.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,645,700.00 | 2,645,000.00 | 700.00 | 99.97 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **23,360,600.00** | **5,624,600.00** | **17,736,000.00** | **24.08** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,300,000.00 | 564,000.00 | 17,736,000.00 | 3.08 |
| 210604 | Урсгал засвар | 5,060,600.00 | 5,060,600.00 | - | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **514,900.00** | **506,000.00** | **8,900.00** | **98.27** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 514,900.00 | 506,000.00 | 8,900.00 | 98.27 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,345,800.00** | **4,345,700.00** | **100.00** | **100.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,193,800.00 | 3,193,700.00 | 100.00 | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,827,000.00** | **4,827,000.00** | **-** | **100.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,827,000.00 | 4,827,000.00 | - | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **45,005,000.00** | **44,639,200.00** | **365,800.00** | **99.19** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - | - | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 45,005,000.00 | 44,639,200.00 | 365,800.00 | 99.19 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 700,000.00 | 700,000.00 | - | 100.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **18,559,400.00** | **(18,559,400.00)** | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 18,559,400.00 | (18,559,400.00) | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 17,670,000.00 | (17,670,000.00) | |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 889,400.00 | (889,400.00) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,293,366,800.00 | 1,276,596,236.97 | 16,770,563.03 | 98.70 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,293,366,800.00 | 1,276,596,236.97 | 16,770,563.03 | 98.70 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 105,278,000.00 | 88,507,436.97 | 16,770,563.03 | 84.07 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,188,088,800.00 | 1,188,088,800.00 | - | 100.00 |

## 6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **16,418,730.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **12,852,230.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 12,852,230.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 934,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 514,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 420,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 11,918,230.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 11,918,230.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **10,270.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 10,270.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **3,566,500.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 3,566,500.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 2,520,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 1,046,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 16,429,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 16,429,000.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | - | 10,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 934,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 4,895,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн /*цаашид Цагааннуур сумын ЕБС гэх*/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ Аудит” ХХК-ийн захирал, аудитор Ч.Цэрэннадмид, ахлах аудитор Ш.Ганчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 41 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагааннуур сумын ЕБС тайлант онд “Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллая.” гэсэн зорилгын хүрээнд дараахь зорилтын дэвшүүлж ажиллажээ. Үүнд:

1.Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах боломж, нөхцөлийг бүрдүүлж, сургууль завсардалгүй сургах

2.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, цахим болон даалгаврын сан бүрдүүлэн ажиллах

3.Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүйгээ хөгжүүлж, хамтран ажиллах

4."Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж" шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэн, эрүүл, аюулгүй, ээлтэй орчинг бүрдүүлэх

5. Судалгаа, арга зүйн байгууллагуудтай хамтран ажиллаж, сургалтын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэн, сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулж ажиллах.

Тус сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Суурь болон бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- БШУ-ны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн А/05, А/10, 1 тоот хамтарсан тушаал "Шалгуур үзүүлэлт шинэчлэх тухай" ур чадвар
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- "Нийгмийн даатгалын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 32 дугаар зүйлийн 1 дүгээр зүйл-д НДШ-ийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын ЕБС нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийн нийт дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт дүн 1,293,366.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,933.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,053.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагааннуур сумын ЕБС-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,283.5 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1:* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Хувь хүнээс авах авлага | 6,308.5 | 6,308.5 | |
| Бараа материал | 69,152.9 | 82,497.5 | 13,344.6 |
| Үндсэн хөрөнгө | 1,809,110.1 | 1,802,048.9 | (7,061.2) |
| **Нийт хөрөнгө** | 1,884,571.5 | 1,890,855.0 | 6,283.5 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,884,571.5 | 1,890,855.0 | 6,283.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,884,571.5 | 1,890,855.0 | 6,283.5 |

Бараа материалын дансны үлдэгдэл 82,497.8 мянган төгрөг болж 13,344.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 106,775.6 мянган төгрөгийн материал худалдан авсан, хандиваар 13,677.2 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, 107,108.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /*анхны өртгөөр*/ 2,159,622.7 мянган төгрөг болж өмнөх оноос 22,160.7 мянган төгрөгөөр өссөн нь 22,125.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, БШУЯ-наас 34,710.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, ном үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 597 тоот албан бичгийг үндэслэн 88,414.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, 34,552.9 мянган төгрөгөөр бүртгэсэн. Мөн аймгийн Орон нутгийн өмчгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 596 тоот албан бичгийг үндэслэн тус сургуулийн урсгал зардлаас санхүүжигдсэн 4,522.5 мянган төгрөгийн өртөгтэй /музейн/ дотуур байрны засварыг тавилга эд хогшилд данснаас барилга, байгууламж, орон сууц дансанд шилжүүлэн бүртгэж, сумын ИТХТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 80 дугаар тогтоолоор 20,613.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассантай тус тус холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,890,855.0 мянган төгрөг болж 6,283.5 мянган төгрөгөөр өссөн нь 4,522.5 мянган төгрөгийн өртөгтэй дотуур байрны засварыг капиталжуулж бүртгэсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,371,443.7 мянган төгрөг болж өмнөх оноос 10,862.2 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 50,880.7 мянган төгрөгөөр өссөн, тусламж санхүүжилтийн орлого 61,742.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,369,682.8 мянган төгрөг болж өмнөх оноос 80,373.8 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Цагааннуур сумын ЕБС нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,178,885.4 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 114,482.0 төгрөгөөр нэмэгдүүлж, 1,293,367.4 мянган төгрөгөөр баталжээ. Бараа, үйлчилгээний зардлыг 184,308.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, урсгал шилжүүлгийн зардлыг 114,132.2 мянган төгрөгөөр бууруулж баталжээ. Цалин, НДШ-ийн зардалд төрийн үйлчилгээний албан хаагчдад олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тооцож төлөвлөөгүй, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг хасаж баталсантай холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,293,366.8 мянган төгрөгийн төсөв баталсныг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,188,088.8 мянга, орон нутгийн төсвөөс 105,278.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,188,088.8 мянга, орон нутгийн төсвөөс 88,507.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,270,960.0 мянган төгрөгийг зарцуулж, 5,636.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,270,960.9 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байна. Энэ нь бараа, ажил үйлчилгээний зардал 27,737.9 мянган төгрөгөөр хэмнэгдэж, хөрөнгийн зардал 22,125.9 мянган төгрөгөөр хэтэрсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БШУЯ-наас хөтөлбөрийн санхүүжилт 10,600.0 мянга, БСУГ-аас 934.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоор /номын түрээс/ 4,895.0 мянга нийт 16,429.0 мянган төгрөг төвлөрснийг хөрөнгө худалдан авахад 3,566.5 мянга, сургалтын үйл ажиллагаанд 12,432.2 мянга, ариутгалын зардалд 420.0 мянган төгрөг тус тус зарцуулж, 10.3 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт

**3.7.1** Боловсролын сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292 А/525 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу цахим болон танхимын сургалтад шилжүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Цагааннуур сумын ЕБС нь тайлант оны үйл ажиллагаанд 1,293,366.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,270.960.0 мянган төгрөг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.8 хувиар буюу 5,636.2 мянган төгрөгөөр хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дунд*

*10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан,төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 91,389.6 мянган төгрөгөөр шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар шилэн дансны мэдээлэлтэй холбоотой алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

**4.1 Зөвлөмж**

***1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:***

*1.1 Илрүүлэлт:* Шилэн дансанд мэдээлбэл зохих 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:* Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Цагааннуур сумын ЕБС | 1 | | | | | | | | 1 | |